


1.



Хайх

ДЭЛГЭРЭНГҮЙ | ХАЙХ

2016 оны 10-р сарын 9, 10м гараг, 21 цаг 31 минут

**ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН СИСТЕМ**• [X](#)[Эрх зүйн акт](#)

- [Сүүлд оруулсан актуул](#)
- [Боловсрол, соёл, шинжлэх ухаан](#)
- [Уул уурхай](#)
- [Хууль зүй](#)

[Мэдээ](#)

- [Ном](#)
- [Судалгаа мэдээлэл](#)


[Сургалт](#)



[Мэдлэгийн сан](#)



[Байгууллага](#)



[Ном](#)

- [Бусад](#)
 - [Тусламж](#)
 - [Аллаа мэдээлэх](#)
 - [Нэвтрэх](#)

[Нэвтрэх](#)

[Тусламж](#)

[Үндсэн нүүр](#) > [Сайдын тушаал](#) > [Уул, уурхайн яам](#) > [ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын/](#)

- [Хууль зүйн акт](#)
- [Хавсралт](#)
- [Жагсаалтруу Буцах](#)



Уул уурхайн сайдын 2015 оны 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Бүлэг 1

Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Зорилго

1.1.Энэхүү журмын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1, 24.2, 26.9, 49.7-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг явуулахад оршино.

1.2.Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн захиргааны байгууллага” гэх) зохион явуулна.

1.3.Сонгон шалгаруулалтыг шударга, ил тод, олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогод нийцүүлэн сонгон шалгаруулалтыг зохион явуулна.

1.5.Сонгон шалгаруулалтын талбай нь тусгай хэрэгцээний газартай давхцалтай, хууль бус олборлолтонд өртсөн, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарч байвал Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дунд сонгон шалгаруулалтыг хязгаарлагдмал байдлаар зохион явуулж болно. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар нэмэлт оруулсныг тусгав/

Хоёрдугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

2.1.Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“Оролцогч” гэдэг нь энэхүү журамд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцохоор санал ирүүлсэн, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдийг;

- 2.1.2.“Санал авах эцсийн хугацаа” гэдэг нь энэхүү журмын 4 зүйлийн 4.2-д заасан хугацааг;
- 2.1.3.“Өдөр тутмын мэдээллийн хэрэгсэл” гэдэг нь Монгол Улсын өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;
- 2.1.4.“Сонгон шалгаруулалтын урилга” гэдэг нь энэхүү журамд заасан, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлагдсан зарыг;
- 2.1.5.“Тусгай зөвшөөрөл” гэдэг нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.15, 4.1.16-д заасан баримт бичгийг;
- 2.1.6.“Шалгарсан оролцогч” гэдэг нь сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчийг;
- 2.1.7.“Сонгон шалгаруулалт” гэдэг нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1, 24.2, 26.9, 49.7-д заасны дагуу энэхүү журмаар тусгай зөвшөөрөл эзэмших хуулийн этгээдийг сонгох үйл ажиллагааг;
- 2.1.8.“Сонгон шалгаруулалтын талбай” гэдэг нь сонгон шалгаруулалтын урилгад заасан талбайг;
- 2.1.9.“Сонгон шалгаруулалтын санал” гэдэг нь сонгон шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн баримт бичгийг;
- 2.1.10.“Сонгон шалгаруулалтын комисс” гэдэг нь энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалтын саналыг үнэлж дүгнэлт гаргах геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлагдсан бүрэлдэхүүнийг;
- 2.1.11.“Сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлт” гэдэг нь энэхүү журмын дагуу явагдсан сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны үр дүнг тодорхойлсон баримт бичгийг;
- 2.1.12.“Сонгон шалгаруулалтын үнийн санал” гэдэг нь сонгон шалгаруулалтад оролцож буй хуулийн этгээдийн санал болгосон мөнгөн дүн;
- 2.1.13.“Босго үнэ” гэдэг нь энэхүү журмын 5.1-д заасан утгаар ойлгоно.

Бүлэг 2

Сонгон шалгаруулалт явуулах нөхцөлийг бүрдүүлэх

Гуравдугаар зүйл. Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах

- 3.1.Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтад заасны дагуу сонгон шалгаруулалтын талбайг ялган багцалж нийтэд зарлана.
- 3.2.Кадастрын асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулах бэлтгэлийг хангана.
- 3.3.Төрийн захиргааны байгууллага сонгон шалгаруулалт явуулах талаар тухайн талбайн байрших аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд Ашигт малтмалын тухай хуулийн 17.1, 24.3-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана.
- 3.4.Засаг дарга нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.4-т заасны дагуу хариуг төрийн захиргааны байгууллагад өгнө.
- 3.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга дэмжсэн хариу өгсөн, Ашигт малтмалын тухай хуулийн 19.5-д зааснаас бусад үндэслэлээр татгалзсан, Ашигт малтмалын тухай хуулийн 19.4-т заасан хугацаанд хариу өгөөгүй бол тухайн талбайд төрийн захиргааны байгууллагын дарга сонгон шалгаруулалт явуулах тушаал гаргаж, сонгон шалгаруулалт явуулна.

Бүлэг 3

Сонгон шалгаруулалтанд оролцогчдыг бүртгэх

Дөрөвдүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын урилга

4.1. Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгасан байна.

4.1.1. Сонгон шалгаруулалтын талбайн байршил, талбайн нэр;

4.1.2. Талбайн солбицол;

4.1.3. Талбайн хэмжээ, гектараар;

4.1.4. Сонгон шалгаруулалтын саналыг ирүүлэх хаяг, хүлээн авах ажилтан;

4.1.5. Сонгон шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа;

4.1.6. Сонгон шалгаруулалтын саналыг нээх хугацаа, газар;

4.1.7. Сонгон шалгаруулалтын босго үнэ; [/Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

4.1.8. Сонгон шалгаруулалтын үнийн саналыг байршуулах дансны дугаар.

4.2. Сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авах эцсийн хугацаа нь өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд сонгон шалгаруулалтын урилга нийтлэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногоос доошгүй байна.

Тавдугаар зүйл. Сонгон шалгаруулалтын саналд тавигдах шаардлага, түүнийг хүлээн авах

5.1. Сонгон шалгаруулалтын талбайн босго үнийг тогтоохдоо нэгж үнийг эрдсийн хуримтлал бүхий талбайд 2244 төг/га, тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд 1800 төг/га, тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд 1350 төг/га байхаар тус тус тооцож, тухайн талбайн хэмжээтэй дүйцэх мөнгөн дүнг “босго үнэ” гэх бөгөөд түүнийг сонгон шалгаруулалтанд оролцогч нь энэхүү журмын 5.3-т заасны дагуу байршуулсан байна.

5.2. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь үнийн санал ирүүлэх бөгөөд энэхүү журмын 5.1-д заасан босго үнийг түүнд оруулж тооцно.

5.3. Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол Банкнд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулж баталгаа гаргуулах бөгөөд уг баталгааг сонгон шалгаруулалтын саналын хамт ирүүлнэ. Баталгааны загварыг төрийн захиргааны байгууллага батална.

5.4. Сонгон шалгаруулалтын санал нь дараах шаардлагыг хангасан байна. [/Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/](#)

5.4.1. Сонгон шалгаруулалтын санал нь эх ба хуулбар хувиас бүрдэнэ;

3/ 5.4.2. Тухайн талбайд санал болгож буй үнийн дүнг тоо болон үсгээр бичиж битүүмжилсэн байх ба тоогоор болон үсгээр бичсэн хоёр тоо зөрүүгүй байна;

4/ 5.4.3. Сонгон шалгаруулалтын саналыг төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу бүрдүүлж, хуудас тус бүрийг дугаарласан байна;

5/ 5.4.4. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д заасан хураамжийг төлсөн байна;

6/ 5.4.5. Сонгон шалгаруулалтанд оролцогчийн санал нь Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд дараах бичиг баримтыг хавсаргасан байна. Үүнд:

- Сонгон шалгаруулалтанд оролцох санал;
- Санал гаргагчийн албан ёсны тодорхойлолт;

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо;
- Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол банкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулсан баталгаа (Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу);
- Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын төрөл хэмжээ, хугацаа, өртөг, болон байгаль хамгаалахад зарцуулах зардлыг тоймлон тусгасан төсөл, төсвийн санал;
- Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна/;
- Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна/;
- Хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах дэвшилтэт арга, аргачлал, технологийн шийдэл;
- Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг;
- Энэхүү журмын 5.4.4-т заасан үйлчилгээний хөлс төлсөн баримт. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар 5.4.1-5.4.5 дахь хэсгийг нэмэлт оруулсныг тусгав/

5.5.Битүүмжилсэн сонгон шалгаруулалтын саналын хавтасны гадна талын зүүн дээд буланд сонгон шалгаруулалтанд оролцохоор санал ирүүлж буй компанийн нэр, хаяг, сонгон шалгаруулалт зарласан талбайн байршил, нэр, сонгон шалгаруулалтын саналын хуудасны нийт тоо, эх эсхүл хуулбар хувийн аль нь болохыг бичсэн байна.

5.6.Оролцогч аж ахуй нэгж, байгууллагын захирал, дарга эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаанд, дурдсан хаягаар, битүүмжилсэн сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн даргад биечлэн хүлээлгэн өгнө. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

5.7.Сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга, комиссын гишүүний хамт хүлээн авч дэвтэрт бүртгэх ба бүртгэсэн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг оролцогчид өгнө. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

5.8.Сонгон шалгаруулалтын санал нь энэхүү журмын 5.5, 5.6-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тэмдэглэл үйлдэн хүлээн авахаас татгалзсан үндэслэл, буцаасан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэсэн тодорхойлолтыг саналын хамт сонгон шалгаруулалтын санал авч ирсэн этгээдэд буцаан өгнө. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

5.9.Шуудангаар илгээсэн саналыг сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй. Уг сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга дэвтэрт тэмдэглэж, сонгон шалгаруулалтын саналыг задлалгүйгээр албан бичигт хавсарган буцаана. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

5.10.Сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаа дуусмагц сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын санал бүртгэх дэвтэрийг хааж, ирүүлсэн нийт сонгон шалгаруулалтын саналыг сонгон шалгаруулах комиссын дарга, гишүүдэд акт үйлдэн хүлээлгэн өгнө. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

Бүлэг 4

Сонгон шалгаруулалтыг явуулах

Зургадугаар зүйл. Сонгон шалгаруулалтын комисс

6.1.Сонгон шалгаруулалт зохион явуулах комиссын бүрэлдэхүүнийг Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлах бөгөөд комиссын гишүүд нь сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ өгч, комисс дүгнэлт гаргана.

6.2.Сонгон шалгаруулалт зохион явуулах комиссын бүрэлдэхүүн нь хууль, эрх зүйн болон хайгуул, ашиглалтын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай байна.

6.3.Комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй байна. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

6.4.Сонгон шалгаруулалт зарласан талбайд ирүүлсэн бүх сонгон шалгаруулалтын санал нь энэ журмын 7.2.2-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах үйл явцыг нээлттэй хэлбэрээр явуулна.

6.5.Комиссын гишүүдийн 70 ба түүнээс дээш хувийн ирцээр сонгон шалгаруулалт хүчин төгөлдөр болох ба комисс нь дараах үүрэг гүйцэтгэнэ: Үүнд:

6.5.1.Сонгон шалгаруулалтыг урилгад заасан газарт, хугацаанд нь эхлүүлэх;

6.5.2.Сонгон шалгаруулалт явуулах тухай төрийн захиргааны байгууллагын даргын тушаалыг танилцуулах, холбогдох асуудлаар оролцогчдоос тавьсан асуултанд тайлбар өгөх;

6.5.3.Сонгон шалгаруулалт зарласан хайгуулын талбайд сонгон шалгаруулалтын санал ирээгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэн Ашигт малтмалын тухай хуулийн 20.3-т заасны дагуу шийдвэрлэх;

6.5.4.Сонгон шалгаруулалт зарласан талбайд нэг санал ирсэн бол сонгон шалгаруулалтыг хүчинтэйд тооцох;

6.5.5.Сонгон шалгаруулалт зарласан талбайд ирүүлсэн бүх сонгон шалгаруулалтын санал нь энэ журмын 7.2.2-д заасан шаардлагыг хангаагүй бол сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож, дахин сонгон шалгаруулалт явуулах тухай дүгнэлт гаргах;

6.5.6.Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэг бүрчлэн үнэн зөв, бүрэн тэмдэглэх.

6.6.Сонгон шалгаруулалтын комисс нь “Төрийн нууцын тухай” хууль, “Байгууллагын нууцын тухай” хууль, “Хувь хүний нууцын тухай” хуульд заасан мэдээллийг задлах, нийтлэх буюу тараахыг хориглоно.

Долдугаар зүйл. Сонгон шалгаруулалтын саналыг нээх

7.1.Сонгон шалгаруулах комисс сонгон шалгаруулалтын урилгад заасан газарт, дурдсан хугацаанд сонгон шалгаруулалтын саналыг нээнэ.

7.2.Саналыг нээх үед:

7.2.1.Сонгон шалгаруулалтын санал ирүүлсэн аж ахуйн нэгж, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулах нөхцөлийг төрийн захиргааны байгууллага бүрдүүлэх;

7.2.2.Сонгон шалгаруулалтанд ирүүлсэн эх саналыг нээж, иж бүрдлийг нь нягтлан шалгаж дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөж, иж бүрдэл нь бүрэн бол тухайн саналыг хүлээн авах;

7.2.3.Төлөөлөл нь хүрэлцэн ирээгүй бол саналыг задлахгүйгээр хүчингүйд тооцож буцаан хүлээлгэн өгнө.

7.2.4.Сонгон шалгаруулалтын санал нь энэхүү журмын 5.4-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд саналыг хүчингүйд тооцож буцаан хүлээлгэн өгнө. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар нэмэлт оруулсныг тусгав/

Наймдугаар зүйл. Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ өгөх

8.1.Сонгон шалгаруулалтын саналыг нээж үзсэний дараа сонгон шалгаруулах комисс шаардлага хангасан сонгон шалгаруулалтын санал тус бүрт үнэлгээ өгнө.

8.2.Сонгон шалгаруулах комиссын гишүүд нь сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ өгөхдөө дараах зүйлсийг шалгуур үзүүлэлт болгон авч үзнэ:

8.2.1.Хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн сонгон шалгаруулалтанд оролцогчид сонгон шалгаруулалтын нийт үнэлгээний 50 хувийн оноог өгнө; /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.2.2.Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын арга аргачлал, төрөл хэмжээ, хугацаа болон байгаль хамгаалах асуудлыг тусгасан төсөл, төсвийн санал; /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.2.3.Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна;/ /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.2.4.Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал /баримтыг нотариатаар гэрчлүүлсэн байна;/ /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.2.5.Хайгуул, ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх дэвшилтэт техник, технологийн шийдэл. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.2.6.Сонгон шалгаруулалтанд оролцогчдын оноо тэнцсэн тохиолдолд түрүүлж саналаа ирүүлсэн оролцогчийг шалгарсанд тооцно.

8.2.7.Орон нутагтай хамтран ажиллах санал, төлөвлөгөө /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар нэмэлт оруулсныг тусгав/

8.3.Энэ журамд заасан сонгон шалгаруулалтын саналыг бүртгэх дэвтрийн загварыг Төрийн захиргааны байгууллагын дарга батална. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.4.Сонгон шалгаруулалтын саналыг ажлын 10 өдөрт багтаан үнэлж, сонгон шалгаруулах комиссын үнэлгээний хуралдааны тэмдэглэл үйлдэнэ. Сонгон шалгаруулалтын саналыг ажлын 10 өдөрт багтаан үнэлж, үнэлгээний хуралдааны тэмдэглэл үйлдэнэ. Үнэлгээг хийхдээ комиссын гишүүдийн өгсөн үнэлгээний онооны дүнг нэмж үнэлгээ өгсөн гишүүдийн тоонд хувааж дундаж оноог гарган, бутархай тоог аравтын орны нарийвчлалтай /зуутын орон нь 5 болон түүнээс дээш байх тохиолдолд зэрэг дэвшүүлнэ/ тодорхойлно. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

8.5.Сонгон шалгаруулалтын саналд энэхүү журмын 5.4.5-т заасан заавал бүрдүүлэх баримт бичгийн бүрдэл дутуу, баримтаар нотлогдоогүй болон илт хуурамч бичиг баримт ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтын комисс үнэлгээ хийхээс татгалзана.

8.6.Сонгон шалгаруулалтанд оролцогчдын техникийн саналыг үнэлсэний дараа үнийн саналыг нээнэ. Үнийн саналыг нээхэд сонгон шалгаруулалтанд оролцогч аж ахуйн нэгжийн эрх бүхий тус бүр нэг төлөөллийг оролцуулж ялагчийг тодруулна.

8.7.Үнийн саналыг нээхэд энэхүү журмын 5.4.2-т заасан шаардлагыг хангаагүй бол үнийн саналд 0 оноо өгнө.

8.8.Сонгон шалгаруулалтын саналын эх ба хуулбар хувь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар 8.5-8.8 дахь хэсгийг нэмэлт оруулсныг тусгав/

Есдүгээр зүйл. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын эрх, үүрэг

9.1.Сонгон шалгаруулалтанд оролцогч нь дараах эрхтэй байна. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

9.2.Сонгон шалгаруулалтын урилгаар зарласан хэдэн ч талбайн сонгон шалгаруулалтанд оролцох эрхтэй.

9.3.Сонгон шалгаруулалтын саналд энэхүү журмын 5.4.5-т заасан заавал бүрдүүлэх баримт бичгийг нотлох баримтын хамт үнэн зөв бүрдүүлж ирүүлэх. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

9.4.Сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлттэй танилцах.

Аравдугаар зүйл. Сонгон шалгаруулалтын дүнг зарлах

10.1.Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор сонгон шалгаруулах комисс нь:

10.1.1.Сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийг төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталгаажуулна;

10.1.2.Сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогч энэхүү журмын 5.2-т заасан сонгон шалгаруулалтын үнийн саналын төлөөгүй үлдсэн зөрүүг ажлын 5 өдөрт багтаан холбогдох төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна;

10.1.3.Сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогч нь энэхүү журмын 5.2-т заасан сонгон шалгаруулалтын үнийн саналд тусгасан мөнгөн дүнг энэхүү журмын 10.1.2-т заасны дагуу ажлын 5 өдрийн дотор төлөөгүй бол тухайн талбайн сонгон шалгаруулалтанд удаах оноо авсан сонгон шалгаруулалтанд оролцогчийг шалгарсанд тооцно;

10.1.4.Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалыг үндэслэн шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтад шалгарсан тухай харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг хүргүүлнэ.

Арван нэгдүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

11.1.Сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн Төрийн захиргааны байгууллагын даргын тушаалын дагуу кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрлийг “Ашигт малтмалын тухай хууль”-д заасны дагуу олгоно. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

11.2.Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь энэхүү журмын 10.1.4-т заасан мэдэгдлийг авснаас хойш тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг ажлын 10 өдөрт багтаан төлнө.

11.3.Шалгарсан оролцогч тусгай зөвшөөрөл авахаас татгалзаж буйгаа бичгээр мэдэгдсэн эсхүл энэ журмын 11.2-т заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрөө төлөөгүй, тухайн сонгон шалгаруулалтанд шалгарсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тухай шүүхийн шийдвэр гарсан бол Төрийн захиргааны байгууллага хамгийн өндөр үнэлгээ авсан дараагийн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргана.

Арван хоёрдугаар зүйл. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

12.1.Сонгон шалгаруулалтанд оролцогч нь энэхүү журмын 5.4-т заасан шаардлагыг хангаагүй, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь холбогдох байгууллагын лавлагаа, дүгнэлтээр тогтоогдсон бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно. /Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/

/Уул уурхайн сайдын 2015-6-29-ний өдрийн 126 дугаар тушаалаар 8.2.6, 12.2 дахь хэсгийг хассан/

Арван гуравдугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх

13.1.Оролцогч нь сонгон шалгаруулалтын комиссыг энэхүү журамд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногт багтаан төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах бөгөөд гомдолд нотлох баримтыг хавсаргана.

13.2.Төрийн захиргааны байгууллагын дарга нь гаргасан гомдлын дагуу сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийг шалгах эрх бүхий ажлын хэсгийг томилох бөгөөд ажлын хэсгийн гаргасан дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргаж энэ талаар оролцогчдод мэдэгдэнэ.

13.3.Оролцогч нь төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу гомдол гаргаж болно.





Зохиогчийн эрх хуулиар
хамгаалагдсан © 2015.

Цахим хуудсыг хөгжүүлсэн



холбоо барих

- Хаяг: Улаанбаатар -46, Чингэлтэй дүүрэг, Чингис хааны талбай-7
- Утас: 976-11312513 Факс: 976-11315735
- И-мэйл: info@legalinfo.mn

эрх зүйн актууд

- → [Монгол Улсын хууль \(599\)](#)
- → [Улсын Их Хурлын тогтоол \(1652\)](#)
- → [Монгол Улсын олон улсын гэрээ \(514\)](#)
- → [Ерөнхийлөгчийн зарлиг \(184\)](#)
- → [Үндсэн хуулийн цэцийн шийдвэр \(236\)](#)
- → [Улсын дээд шүүхийн тогтоол \(173\)](#)
- → [Засгийн газрын тогтоол \(4269\)](#)
- → [Сайдын тушаал \(874\)](#)
- → [Засгийн газрын агентлагийн даргын тушаал \(157\)](#)
- → [УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр \(71\)](#)
- → [Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр \(76\)](#)
- → [Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж \(57\)](#)

[Дээр очих](#)

Хайх утгаа оруулаад Enter товч дарна уу.